



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 670

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 04 дүгээр тогтоол, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 77 дугаар захирамж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/16 дугаар захирамж, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2024 оны А/243 дугаар захирамж, Ханбогд сумын Засаг даргын 2024 оны А/77 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/858 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэрээр төрийн өмчид хүлээн авсан болон Баянхонгор, Дорноговь, Сэлэнгэ, Өмнөговь, Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бий болсон, нийт 120,419,000.00 (нэг зуун хорин сая дөрвөн зуун арван есөн мянга) төгрөгийн балансын үнэ, 12,225,000.00 (арван хоёр сая хоёр зуун хорин таван мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133002733
29-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
630... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Санхүүжүүлсэн байгууллагын нэр	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
1. Сэлэнгэ аймаг дахь ШШГТ									
1	1	Резин сумтай буу /Atrox tactic plus telescopic, pistol/	1	3,390,000.00	3,390,000.00	-	3,390,000.00	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар	Сэлэнгэ аймаг дахь ШШГТ
		Дүн			3,390,000.00		3,390,000.00		
2. Өмнөговь аймаг дахь ШШГТ									
4	1	Суурин компьютер	4	4,300,000.00	17,200,000.00	-	17,200,000.00	Өмнөговь аймаг дахь Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар	Өмнөговь аймаг дахь ШШГТ
5	2	Зөөврийн компьютер	1	3,500,000.00	3,500,000.00	-	3,500,000.00		
6	3	Гар станц	6	450,000.00	2,700,000.00	-	2,700,000.00		
7	4	Камер /энгэрийн/	6	500,000.00	3,000,000.00	-	3,000,000.00		
		Дүн			26,400,000.00	-	26,400,000.00		
3. Баянхонгор аймаг дахь ШШГТ									
8	1	Автомашин-Тоёота приус-30, 33-27 БНН	1	16,300,000.00	16,300,000.00	12,225,000.00	4,075,000.00	Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 77 дугаар захирамж	Баянхонгор аймаг дахь ШШГТ
9	2	Цахим утгагч самбар	1	2,250,000.00	2,250,000.00	-	2,250,000.00		
		Дүн			18,550,000.00	12,225,000.00	6,325,000.00		
4. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар									
11	1	4 хаалгатай шкаф	2	147,500.00	295,000.00	-	295,000.00	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1597 дугаар шийтгэх тогтоол	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
12	2	Шургуулгатай ширээ	2	147,500.00	295,000.00	-	295,000.00		
		Дүн			590,000.00		590,000.00		

Д/д	Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Санхүүжүүлсэн байгууллагын нэр	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
5.Хөвсгөл аймаг дахь ШШГГ									
13	1	Автомашин -Приус-30 /80-40 ХӨН/	1	25,000,000.00	25,000,000.00	-	25,000,000.00	Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 04 дүгээр тогтоол	Хөвсгөл аймаг дахь ШШГГ
		Дүн			25,000,000.00		25,000,000.00		
6.407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги									
14	1	Автомашин-Хьюндай старекс /09-95 УАС/	1	41,700,000.00	41,700,000.00	-	41,700,000.00	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/858 дугаар захирамж	407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги
		Дүн			41,700,000.00		41,700,000.00		
7.Ханбогд сум дахь ШШГХ									
15	1	Нөөц үүсгүүр	1	1,950,000.00	1,950,000.00	-	1,950,000.00	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2024 оны А/243 дугаар	Ханбогд сум дахь ШШГХ
16	2	Агаар сэлгэх төхөөрөмж	1	1,469,000.00	1,469,000.00	-	1,469,000.00		
		Дүн			3,419,000.00		3,419,000.00		
8.Замын-Үүд сум дахь ШШГХ									
17	1	Зургийн аппарат /Canon 60 D/	1	1,370,000.00	1,370,000.00	-	1,370,000.00	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/16 дугаар захирамж	Замын-Үүд сум дахь ШШГХэлтэс
		Дүн			1,370,000.00	-	1,370,000.00		
17		Нийт дүн			120,419,000.00 (нэг зуун хорин сая дөрвөн зуун арван есөн мянга)	12,225,000.00 (арван хоёр сая нэг зуун найман сая нэг дүүн ерэн дөрвөн мянга)	108,194,000.00 (нэг зуун найман сая нэг дүүн ерэн дөрвөн мянга)		